

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

Агуулга.....	1
1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн хөгжлийн банк



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР
ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ
ХӨТӨЛБӨР ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ Д.АВИРМЭД ТАНАА

2020.05.14 № 06/1818
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтөлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөл нь төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн зохицуулагч Д.Авирмэд Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үндсэн хөрөнгөд тооллого хийх, элэгдэж дууссан хөрөнгүүдийг ТУХ-ийн шийдвэрийн дагуу элэгдлийн хугацааг дахин тогтоох, данснаас хасах, гүйцэтгэгч нарын барьцааг өглөгөөр бүртгэх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих” төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 04 дүгээр сарын 13-наас 2020 оны 05 дүгээр сарын 01-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 05 дүгээр сарын 01-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төслийн нэгжийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК-ийн Чанарын хяналтын менежер Х.Дорж, ахлах аудитор Т.Сугарсүрэн, аудиторын туслах П.Ганчимэг, Т.Энхжаргал нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн 2019 оны санхүүгийн тайланг “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК-д 2020 оны 2 дугаар сарын 11-ны өдрийн 145 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

МУ-ын Засгийн газар болон Азийн хөгжлийн банкны хооронд 2013 оны 12 дугаар сарын 09-ний өдөр “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийг хэрэгжүүлэхээр гэрээг байгуулсан. Төслийн нийт төсөвлөсөн зардал 320.0 сая ам.доллар ба АХБ-ны зээлээр 160.0 сая ам.доллар, АХБ-ны тусламжаар 3.7 сая ам.доллар, Улаанбаатар хотын захиргаанаас 96.0 сая ам.доллар, Европын Хөрөнгө оруулалтын банкнаас 60.3 сая ам.долларыг тус тус санхүүжүүлэхээр тохирсон байна.

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн зорилго нь зорилтот дэд төвүүдийн доторх авто зам, хотын үйлчилгээг өргөтгөх, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах, дэд төвүүд дэх эдийн засгийн болон дэд бүтцийн үйлчилгээг нэмэгдүүлэх, үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, хот байгууллалтын хөтөлбөрийн менежмент, үйлчилгээг хүргэх чиглэлээр институцийг бэхжүүлж, чадавхыг бүрдүүлэх 3 үе шаттайгаар 6 дэд төвийн хөгжлийн суурь нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Төслийн 1-р үе шатны хүрээнд Баянхошуу, Сэлбийн дэд төвүүд, 2-р үе шатны хүрээнд Дамбадаржаа, Дэнжийн мянга дэд төвүүд, 3-р үе шатны хүрээнд Толгойт, Шархад дэд төвүүд багтаж байна.

Үйл ажиллагааны чиглэл:

Хөтөлбөрийн хүрээнд хотын дэд бүтцийн үндсэн салбарууд болох ус хангамж, ариутгах татуурга, дүүргийн халаалт, авто замуудын ажлыг санхүүжүүлэх бөгөөд оршин суугчдын эрэлт хэрэгцээний дагуу нийгэм эдийн засгийн байгууламжид хөрөнгө оруулалт хийх, дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйлчилгээний чанарыг сайжруулах зэрэг ажлууд хийгдэнэ.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Смарт Ложик” ХХК-ийн “Смарт Аккаунтинг” программ хангамж ашигладаг байна.

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 6 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн “нийт хөрөнгө”-ийн дүнг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 234,995,683.5 мянган төгрөгөөс тооцон 2,349,956.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өөрчлөөгүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 160,579,036.7 мянган төгрөгөөр буюу 54.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бусад эргэлтийн хөрөнгө, байгууллагад төлөх өглөг, урьдчилж орсон орлогын дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,418,874.9	22,877,402.4	18,458,527.5
Авлага	797.5	3,207.1	2,409.6
Бараа материал	16,250.8	-	(16,250.8)
Бусад эргэлтийн хөрөнгө	69,859,406.0	212,012,457.8	142,153,051.7
Үндсэн хөрөнгө	121,317.6	102,616.2	(18,701.3)
Нийт хөрөнгө	74,416,646.8	234,995,683.5	160,579,036.7
Бусад өглөг	26.8	-	(26.8)
Ажилчидтай холбогдсон өглөг	20,628.5	2,935.0	(17,693.5)
Байгууллагад төлөх өглөг	3,265,979.6	14,116,550.1	10,850,570.5
Татвар, НДШ-ийн өглөг	-	305.6	305.6
Урьдчилж орсон орлого	-	18,058,592.3	18,058,592.3
Засгийн газрын оролцоо			
Өмнөх үеийн үр дүн	33,689,795.7	104,300,243.8	70,618,448.1
Тайлант үеийн үр дүн	37,440,216.2	98,517,056.7	61,076,840.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	74,416,646.8	234,995,683.5	160,579,036.7

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь үе шат 2-т зориулан 3 тусгай дансдыг Төрийн банкинд шинээр нээн тайлант хугацаанд уг дансад нийт 6,635.0 мянган ам.доллар буюу 17,686,335.4 мянган төгрөгийн урьдчилгааг хүлээн авсан байна.

Бусад эргэлтийн хөрөнгөнд төслийн хүрээнд Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдэд хийгдэж буй авто зам, усан хангамж, ариутгах татуурга, дулааны шугам сүлжээ, холбооны шугам сүлжээ зэрэг инженерийн дэд бүтцийн барилга угсралтын ажлууд, их засвар, өргөтгөл, шинэтгэлийн ажлууд, төслийн менежментэд дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээ, газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлт, зээлийн хүүгийн зардал, Гааль татвар болон НӨАТ-ыг чөлөөлөх замаар оруулж буй МУ-ын Засгийн газрын хувь оролцоог хуримтлуулан бүртгэсэн. Нийт 212,012,457.8 мянган төгрөгийн бусад эргэлтийн хөрөнгийг харьяа байгууллагууд болон захиалагч байгууллагад барилга байгууламж, их засвар, шинэчлэлтийн зүгшрүүлэх, тохируулах хугацаа гэрээний дагуу болоогүй, гэрээт ажил бүрэн

хийгдэж дуусаагүй, тухайн байгууламжийн цаашдын ашиглагч, үйлчилгээг хариуцагч байгууллага тодорхойлогдоогүй зэрэг шалтгаанаар шилжүүлээгүй бүртгэлтэй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь МОН-3098 (OCR) болон МОН-3525 (OCR) хамтарсан санхүүжилтийн эх үүсвэрүүдийн хүрээнд хийгдэж буй нийт 12 гэрээт ажлын 13,950,403.7 мянган төгрөгийг Нийслэлийн 2019 оны төсөв хүрэлцээгүйн улмаас 2020 онд санхүүжүүлэхээр болсноос шалтгаалжээ. Байгууллагад төлөх өглөг дансанд бүртгэгдсэн гэрээт ажлын гүйцэтгэгчидтэй өглөгийн тулган баталгаажуулалтыг бүрэн хийж гүйцэтгэсэн байна.

Урьдчилж орсон орлогын дансанд үе шат 2-ийн үйл ажиллагааны хүрээнд 2019 онд авсан урьдчилгаа санхүүжилт, ажил нь явагдаж дуусаагүй байгаа орлогоор хүлээн зөвшөөрөгдөөгүй санхүүжилтыг бүртгэсэн байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хүснэгт 2. Нийт орлогын батлагдсан төсөв, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	87,000,000.0	87,340,337.7	(340,337.7)	100.4
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		96,199.6	(96,199.6)	-
Орон нутгийн төсвөөс /хөрөнгө оруулалт/	18,000,000.0	17,990,814.1	9,185.9	99.9
Орон нутгийн төсвөөс /урсгал зардал/	242,853.0	242,850.1	2.9	99.9
Нийт дүн	105,242,853.0	105,670,210.5	(427,348.5)	100.4

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөл 1 болон 2-т зориулан 87,000,000.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 87,340,337.7 мянган төгрөгийн санхүүжилт орж ирсэн байна.

Орон нутгийн буюу Нийслэлийн хөрөнгө оруулалтын төсөвт 18,000,000.0 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлд 17,990,814.1 мянган төгрөг, үйл ажиллагааны урсгал зардлын төсөвт 242,853.0 мянган төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 242,850.1 мянган төгрөг, үүнээс буцаан төвлөрүүлсэн шилжүүлэг 2.9 мянган төгрөг байна.

Хүснэгт 3. Төсвийн зарцуулалт

/мянган төгрөг/

Зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Барилга байгууламж	74,038,768.2	69,118,447.5	4,920,320.7	93.3
Урсгал зардал	242,853.0	242,850.1	2.9	99.9
Нийт дүн	74,038,768.2	69,118,447.5	4,920,320.7	93.3

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөл 1 болон 2-т зориулан хөрөнгийн зардалд 74,038,768.2 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 69,118,447.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 69,118,447.5 мянган төгрөг буюу 93.3 хувьтай байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 4 эрсдэл тодорхойлж нийт 6 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 502,106.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 201,579.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 300,527.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 1 асуудлаар нийт 201,579.0 мянган төгрөгийн алдааг залруулан тайлагнасан. Үүнд:

2018 оны бараа, үйлчилгээний худалдан авалтын НӨАТ-ын чөлөөлөлт 201,579.0 мянган төгрөгийг Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалын 8 дугаар зүйл 8.2.3-т “Санхүүгийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бүртгэж, цаг хугацаанд нь тайлагнах” гэсний дагуу залрууллаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн 2 дахь үе шат Дамбадаржаа, Дэнжийн мянгын дэд бүтцийн ажлын урьдчилгаа санхүүжилт 2019 онд хийгдсэн. Иймээс урьдчилгаа санхүүжилттай холбоотой худалдан авалтуудыг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан хугацаанд нь ил тод мэдээлж байршуулсан байна.

Аудитаар “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөл нь тайлант онд шилэн дансандаа төсөв, гүйцэтгэл, хөрөнгө оруулалт тендер, худалдан авалт, бусад гэсэн нийт 148 мэдээлэл байршуулсан ба үүнээс 116 мэдээллийг хугацаандаа, 32 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 73,178,869.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Үндэсний Аудитын газрын захиалгаар “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн 2018 оны санхүүгийн тайланд өгсөн зөвлөмжийн дагуу “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслөөс дараах бүртгэлүүдийг залруулсан. Үүнд:

- “Бусад эргэлтийн хөрөнгө” дансны 2018 оны үлдэгдэл 69,859,406.0 мянган төгрөгийн хуримтлагдсан зардлыг төсөл, хөтөлбөр болон гүйцэтгэгдэж буй объектоор нь дансны төлөвлөгөөтэй уялдуулан бүртгэсэн.
- Төслийн зээлийн гэрээнд тусгагдсаны дагуу Монгол Улсын Засгийн газраас оруулсан 2018 оны байдлаарх 3,319,463.6 мянган төгрөгийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлангаар баталгаажуулан бүртгэсэн.
- Төслийн гэрээнд тусгагдсаны дагуу Монгол Улсын Засгийн газраас санхүүжүүлсэн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн нөхөн олговрыг Нийслэлийн Газрын албатай тооцоо нийлэн баталгаажуулж санхүүгийн тайланд тусгасан.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Төслийн үндсэн хөрөнгөнд тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй. Мөн 66,841.5 мянган төгрөгийн компьютер, дагалдах хэрэгслүүд нь бүрэн элэгдэж дууссан боловч данснаас хасах эсвэл дахин ашиглах ямар нэгэн шийдвэр гараагүй.

3.1.2 Эрсдэл: Үндсэн хөрөнгөнд тооллого хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө заавал хийнэ” гэснийг мөрдөж ажиллаагүй, үндсэн хөрөнгийн иж бүрэн байдлын батламж мэдэгдлийг хангахгүй байх эрсдэлтэй.

3.1.3 Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн тооллогыг жил бүр зохион байгуулах, бүрэн элэгдэж дууссан хөрөнгүүдийг цаашид ашиглахаар бол компьютер ашиглалтын хугацааг дахин тогтоох, хэрэглэхгүй үндсэн хөрөнгүүдийг данснаас хасах шийдвэр гаргуулах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Төслийн урсгал үйл ажиллагааны зардал нь НЗДТГ-аас 100% санхүүждэг бөгөөд тавилга, эд хогшил, компьютер тоног төхөөрөмжийг ашиглалтын хугацааг дахин тооцох, мэргэжлийн байгууллагад хандах зэрэг үйл ажиллагаа явуулахад төсөв хүрэлцээгүй байдаг.

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт: Төслийн Баянхошуу, Сэлбийн дэд төвүүдэд хийгдэж дууссан дэд бүтцийг шинээр бий болгох, түүний зөвлөх үйлчилгээний Гүйцэтгэгч нарт олгох 233,686.1 мянган төгрөгийн гүйцэтгэлийн барьцаа мөнгийг санхүүгийн тайланд Урьдчилж орсон орлогоор алдаатай ангилж бүртгэсэн байна.

3.2.2 Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, Нягтлан бодох бүртгэлийн хууль, журам зөрчилдөх

- 3.2.3 Өгсөн зөвлөмж: Гүйцэтгэлийн барьцаа мөнгийг гүйцэтгэгч тус бүрээр тусад нь өглөг үүсгэн санхүүгийн тайланд тусгах, барьцааны хугацаа дуусахад гүйцэтгэгч нартай тооцоо нийлж зохих дүнгээр барьцааг олгох
- 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Барилгын тухай хуулийн 4.1.3.“барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа” гэж барилга байгууламжийг ашиглалтад оруулж, гэрчилгээ олгосноос хойш захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, зөвлөх үйлчилгээ гүйцэтгэгч болон барилгын үйл ажиллагаанд оролцогч бусад этгээд барилгын хийц, бүтэц, эзлэхүүн, тоног төхөөрөмж, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны ашиглалтын хэвийн нөхцөлийг хариуцан хангах хугацааг" хэлнэ гэж заасны дагуу энэ хугацаа дууссаны дараа акт үйлдэгдсэний үндсэн дээр санхүүжилтийг олгодог. Энэ хугацаанд аливаа эвдрэл гэмтлийг үл маргах журмаар барьцаа хөрөнгөнөөс өөр гүйцэтгэгчээр ажлыг нь хийлгүүлэх зэрэг замаар гаргаж авдаг бөгөөд барьцаа хөрөнгө нь гүйцэтгэгчид өглөг болох үндэслэлийг 100% хангахгүй гэж үзсэний үндсэн дээрээс барьцааны өглөг үүсгээгүй болно.

3.3 Шилэн данстай холбоотой асуудал

- 3.3.1 Илрүүлэлт: Тайлант онд шилэн дансандаа төсөв, гүйцэтгэл, хөрөнгө оруулалт тендер, худалдан авалт, бусад гэсэн нийт 148 мэдээлэл байршуулснаас 116 мэдээллийг хугацаандаа, 32 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.
- 3.3.2 Эрсдэл: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх зарчмыг баримтална” гэснийг мөрдөж ажиллагаагүй.
- 3.3.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн дагуу хугацаандаа мэдээллүүдээ байршуулах
- 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Балансын үзүүлэлт	2019 оны 01-р сарын 01 өдөр	2019 оны 12-р сарын 31 өдөр
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	4,418,874,937.27	22,877,402,377.32
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-
Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	69,622,477.86	134,367,770.84
Банкинд байгаа бэлэн мөнгө /гадаад валютаар/	4,349,252,459.41	22,743,034,606.48
АВЛАГА	797,484.74	3,207,068.36
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-
Бусад авлага	797,484.74	3,207,068.36
БАРАА МАТЕРИАЛ	16,250,790.53	-
Хангамжийн материал	16,250,790.53	-
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	69,859,406,045.78	212,012,457,793.85
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	69,859,406,045.78	212,012,457,793.85
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	74,295,329,258.32	234,893,067,239.53
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	121,317,550.03	102,616,222.03
Биет хөрөнгө	121,317,550.03	102,616,222.03
Авто-тээврийн хэрэгсэл	113,950,000.00	113,950,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(39,882,500.00)	(51,277,500.00)
Машин тоног төхөөрмж (компьютер)	66,841,500.00	66,841,500.00
Хуримтлагдсан элэгдэл	(66,841,500.00)	(66,841,500.00)
Тавилга, аж ахуйн эд хогшил	73,063,279.90	73,063,279.90
Хуримтлагдсан элэгдэл	(25,813,229.87)	(33,119,557.87)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	121,317,550.03	102,616,222.03
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	74,416,646,808.35	234,995,683,461.56
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
Өглөг	3,286,634,816.83	14,119,790,612.04
Ажилчидтай холбогдсон өглөг	20,628,501.71	2,934,987.64
Бусад өглөг	26,755.05	-
Байгууллагад төлөх өглөг	3,265,979,560.07	14,116,550,095.45
Татвар, НДШ-ийн өглөг	-	305,528.95
Урьдчилж орсон орлого	-	18,058,592,349.94
Урьдчилж орсон орлого	-	18,058,592,349.94
БОГИНО ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН	3,286,634,816.83	32,178,382,961.98
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	3,286,634,816.83	32,178,382,961.98
Засгийн газрын хувь оролцоо	71,130,011,991.52	202,817,300,499.58
Хуримтлагдсан үр дүн	71,130,011,991.52	202,817,300,499.58
Өмнөх үеийн үр дүн	33,689,795,741.30	104,300,243,818.43
Тайлант үеийн үр дүн	37,440,216,250.22	98,517,056,681.15
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	71,130,011,991.52	202,817,300,499.58
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	74,416,646,808.35	234,995,683,461.56

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	38,334,634,930.86	99,936,086,212.68
Гадаад зээлийн эх үүсвэрээс санхүүжих	33,086,899,081.29	70,542,059,019.68
Хүүгийн орлого / тусгай данс /		
Улсын төсвөөс		
Орон нутгийн төсвөөс	5,247,735,849.57	9,932,723,511.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	19,461,303,682.00
Бараа үйлчилгээний орлого	131,331,229.12	96,307,818.32
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	119,148,429.12	89,294,018.32
Бусад орлого	12,182,800.00	7,013,800.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	38,465,966,159.98	100,032,394,031.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
АЖИЛЛАГЧИДАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	747,932,933.61	963,877,069.34
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	666,385,481.65	856,364,569.34
Гэрээт ажлын хөлс	666,385,481.65	856,364,569.34
Нийгмийн хамгааллын шимтгэл	81,547,451.96	107,512,500.00
Тэтгэврийн даатгал	81,547,451.96	107,512,500.00
БУСАД БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	166,880,602.91	160,428,024.54
Бичиг хэргийн материал	4,908,920.00	7,006,160.19
Тээвэр, шатахууны зардал	21,810,852.75	11,707,884.29
Шуудан холбооны зардал	6,210,227.25	6,376,455.52
Томилолт, зочны зардал	3,000,000.00	1,800,000.00
Байрны түрээсийн зардал	81,540,000.00	87,060,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	13,715,589.24	495,509.26
Даатгалын үйлчилгээ	-	1,174,700.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	20,000,000.00
Тээврийн хэрэгслийн татвар	-	157,400.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	55,000.00
Элэгдлийн зардал	25,878,944.67	18,701,328.00
Бусад бараа үйлчилгээний зардал	12,816,069.00	5,893,587.28
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,750,442.04	2,900.00
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,750,442.04	2,900.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	937,563,978.56	1,124,307,993.88
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	37,528,402,181.42	98,908,086,037.12
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО		
Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (бодит)		456,721,263.96
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)		456,721,263.96
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		
Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз	(88,185,931.20)	(847,750,619.93)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	(88,185,931.20)	(847,750,619.93)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI)=(IV)-(V)	(88,185,931.20)	(391,029,355.97)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	37,440,216,250.22	98,517,056,681.15

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Татаас, санхүүжилтийн орлого		
Орон нутгийн төсвөөс	232,412,500.00	242,853,000.00
Төсвийн захирагчдаас	5,015,323,349.57	9,689,870,511.00
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	20,076,035,579.13	48,784,925,799.36
Тусламжийн орлого	941,746,579.55	-
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	131,331,229.12	673,228,568.50
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	26,396,849,237.37	59,390,877,878.86
Цалин хөлс нэмэгдэл болон урамшил	666,385,481.65	854,505,382.20
Үндсэн цалин, гэрээт ажлын хөлс	666,385,481.65	854,505,382.20
Нийгмийн хамгааллын шимтгэл	81,547,451.96	107,512,500.00
Тэтгэврийн даатгал	81,547,451.96	107,512,500.00
Бараа, үйлчилгээний урсгал зардал	169,809,619.67	141,481,428.46
Бичиг хэргийн материал	4,908,920.00	7,006,160.19
Тээвэр, шатахууны зардал	21,810,852.75	11,707,884.29
Шуудан холбооны зардал	6,210,227.25	6,376,455.52
Томилолт, зочны зардал	3,000,000.00	1,800,000.00
Байрны түрээсийн зардал	81,540,000.00	87,060,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	13,644,606.00	250,241.18
Даатгалын үйлчилгээ	-	1,174,700.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	20,000,000.00
Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо	-	212,400.00
Бусад бараа үйлчилгээний зардал	38,695,013.67	5,893,587.28
Урсгал шилжүүлэг	19,750,442.04	577,031,852.98
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,750,442.04	577,031,852.98
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	937,492,995.32	1,680,531,163.64
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	25,459,356,242.05	57,710,346,715.22
Дотоод эх үүсвэрээр	5,015,323,349.57	9,689,870,511.00
Гадаад эх үүсвэрээр	21,233,484,188.48	29,702,386,403.45
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (V)	26,248,807,538.05	39,392,256,914.45
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨН/ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(26,248,807,538.05)	(39,392,256,914.45)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	415,025,696.86
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	(88,185,931.20)	(274,588,057.58)
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (VII)	(88,185,931.20)	140,437,639.28
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(877,637,227.20)	18,458,527,440.05
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,296,512,164.47	4,418,874,937.27
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,418,874,937.27	22,877,402,377.32

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	33,689,795,741.30	33,689,795,741.30
Нягтлан бодорх бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	33,689,795,741.30	33,689,795,741.30
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	37,440,216,250.22	37,440,216,250.22
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	71,130,011,991.52	71,130,011,991.52
Нягтлан бодорх бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	33,170,231,826.91	33,170,231,826.91
Залруулсан үлдэгдэл	-	-	104,300,243,818.43	104,300,243,818.43
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	98,517,056,681.15	98,517,056,681.15
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	202,817,300,499.58	202,817,300,499.58

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	242,853,000.00	242,850,100.00	2,900.00	99.9
УРСГАЛ ЗАРДАЛ	242,853,000.00	242,850,100.00	2,900.00	99.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	242,853,000.00	242,850,100.00	2,900.00	99.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,512,500.00	107,512,500.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	107,512,500.00	107,512,500.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87,060,000.00	87,060,000.00	-	100.0
Байрны түрээс	87,060,000.00	87,060,000.00	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	25,090,500.00	25,090,500.00	-	100.0
Бичиг хэрэг	5,890,500.00	7,006,160.19	(1,115,660.19)	118.9
Тээвэр, шатахуун	12,000,000.00	11,707,884.29	292,115.71	97.6
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,200,000.00	6,376,455.52	823,544.48	88.6
Томилолт, зочны зардал	1,800,000.00	1,800,000.00	-	100.0
Зочин төлөөлөгч хүлээн авах	1,800,000.00	1,800,000.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,390,000.00	21,387,100.00	2,900.00	99.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	20,000,000.00	20,000,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	1,174,700.00	1,174,700.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар, оношлогоо	215,300.00	212,400.00	2,900.00	99.9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	242,853,000.00	242,850,100.00	2,900.00	99.9
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	242,853,000.00	242,850,100.00	2,900.00	99.9
Орон нутгийн төсвөөс санхүүжих	242,853,000.00	242,850,100.00	2,900.00	99.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4,418,874,937.27		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		22,877,402,377.32		
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
Байгууллагын тоо	1	1		
Ажиллагсдын тоо	23	23		
Удирдах ажилтан	1	1		
Гүйцэтгэх ажилтан	22	22		

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код:
2020/05/01			САГ-2020/745/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөл		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Төслийн үндсэн хөрөнгөнд тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй. Мөн 66,841.5 мянган төгрөгийн компьютер, дагалдах хэрэгслүүд нь бүрэн элэгдэж дууссан боловч данснаас хасах эсвэл дахин ашиглах ямар нэгэн шийдвэр гараагүй.	66,841.5	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч, Санхүүгийн мэргэжилтэн	Д.Авирмэд Г.Баасансүрэн Б.Нарандулам
2	Төслийн Баянхошуу, Сэлбийн дэд төвүүдэд хийгдэж дууссан дэд бүтцийг шинээр бий болгох, түүний зөвлөх үйлчилгээний Гүйцэтгэгч нарт өгөхгүйцэтгэлийн барьцаа мөнгийг санхүүгийн тайланд Урьдчилж орсон орлогоор алдаатай ангилж бүртгэсэн байна.	233,686.1	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч, Санхүүгийн мэргэжилтэн	Д.Авирмэд Г.Баасансүрэн Б.Нарандулам
3	Тайлант онд шилэн дансандаа төсөв, гүйцэтгэл, хөрөнгө оруулалт тендер, худалдан авалт, бусад гэсэн нийт 148 мэдээлэл байршуулснаас 32 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	-	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч, Санхүүгийн мэргэжилтэн	Д.Авирмэд Г.Баасансүрэн Б.Нарандулам
	Нийт	300,527.6			

